

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНД
САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАГ-2019/02/-ГА

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНД
САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГТ
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор хот 2019 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга**
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер Д.Цэцэгмаа

Утас: 70442424 цахим хуудас: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Б.Цэрэнчимэд

Утас: 88302569 цахим хуудас: tserenchimedb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу

1 ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторын Орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/103 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах дараах чиглэлээр аудит хийв.Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх
3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

Аудитад Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 8/03 тоот “Баянхонгор аймгийн 2018 оны төсвийн тухай” тогтоолоор 2018 онд хэрэгжүүлэх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 27 ажилд 910,0 сая төгрөгийг баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2018 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 12 дугаар хуралдааны 12/02 тогтоолоор өмнөх 8/03 тогтоолд батлагдсан 27 ажлаас заримыг хасаж, зарим ажил нэмж, анх батлагдсан 910,0 сая төгрөгт багтаан зохицуулалт хийж, шинэчилсэн байна.

Мөн 2018 онд сумдын ЗДТГ-ын төсөвт багтаан орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт бүлэг дээр 944,1 сая төгрөгийн төсөв батлагдан 896,4 мянган төгрөгийг зарцуулж, 83,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн ЗДТГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан

авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

Үүнд:

- Барилгын тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Монгол улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”.
- Батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрд хяналт тавьж, аудитор Б.Цэрэнчимэд, аудитор Б.Азбаяр нар 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, аймгийн ИТХ, Засаг дарга болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Баянхонгор аймгийн “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийлээ.

2018 онд орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаар 203,4 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж, 854,8 мянган төгрөгийн автомашин, тээврийн хэрэгсэл худалдан авах, 50,0 сая төгрөгийн засвар, үйлчилгээ хийх буюу нийт 1108,2 мянган төгрөгийн төсвийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар баталсан байна. Мөн ангилагдаагүй зардлаас “Торгон сүрэг” дэд хөтөлбөрт 50,0 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 400,0 сая төгрөг /ЖДҮ-ийг дэмжих зээл/, Жимс жимсгэний тариаланг дэмжих хөтөлбөрт 50,0 сая төгрөг тус тус баталжээ.

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга, хэмжээний хэрэгцээ шаардлага, ТЭЗҮ-ийг урьдчилан тооцоогүй, төрийн чиг үүрэгт хамааралгүй, төрийн бус байгууллагад хөрөнгө батласан байна.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг урьчилан тооцоогүй байхад хуралдааны явцад хэлэлцэж батласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг төсвийн шууд захирагчаас саналыг авч нэгтгэн эрэмбэлсэн судалгааг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс шаардсан боловч ирүүлээгүй. Энэ талаар ХОХБТ-ийн холбогдох мэргэжилтнээс тодруулахад “ төсөв батлагдахаас өмнө байгууллагын дарга удирдлагуудтай уулзаж хэрэгцээ шаардлагын талаар ярилцаж, шийдвэрлэдэг ба тухайн үеийн ярилцлагын тэмдэглэлийг баталгаажуулаагүй, хувийн тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэл хөтөлж байсан” гэсэн тайлбарыг өгсөн болно.

Аудитын явцад олдсон баримт, материалын хэмжээнд дээрх батлагдсан төсөл арга хэмжээ нь зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байгаа эсэхийг тодруулахад МХГазар 2017.08.30-ны өдөр 1/373, Татварын хэлтэс 2017.08.11-ний 291 тоот албан бичгээр зайлшгүй шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийн судалгааг, ЭМГазрын

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

2017.11.13-ны 489 тоот албан бичгээр Энхбүрд, Эрдэнэмандал өрхийн эмнэлэгт автомашин шаардлагатай байгааг, БОАЖГазар 2017.11.16-ны 402 тоот албан бичгээр автомашин шаардлагатай байгаа тухай санал, хүсэлтээ аймгийн ИТХ болон аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хийгдэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тооцоогүй батлагдсан төсөл, арга хэмжээнүүд

№	Төсөл арга хэмжээний нэр	Нийт дүн /мян.төг/	Үндсэн байгууллагаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг, тооцоо судалгаа
Төсөвт байгууллагуудын тоног төхөөрөмж			
1	Санхүүгийн хяналт, аудитын албаны компьютер, техник хэрэгсэл	4,200.0	Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018.02.08-ны 36 тоот албан бичгээр худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалт, үзүүлэлтийг аймгийн СТСХэлтэст ирүүлсэн байна.
2	ОНӨГазрын компьютер, техник хэрэгсэл	1,200.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
3	Аймгийн ИТХ-ын компьютер, техник хэрэгсэл	3,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
4	Аймгийн ЗДТГ-ын компьютер техник хэрэгсэл	25,857.5	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
5	Иргэний танхимын засвар	7,192.5	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
6	Аймгийн ЗДТГ-т автомашин	45,110.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
7	Улаанзагалмайн автомашин	30,000.0	2018.10.04-ний А/26 тоот албан бичгээр автомашин нийлүүлэгчийг сонгон шалгаруулалт зохин байгуулах хүсэлт ирүүлжээ.
8	Баян-Өндөр сум автомашин	50,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
9	Баянлиг сум автомашин	30,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
10	Бөмбөгөр сум ЗДТГ-ын халаалт	9,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
11	Баянбулаг сумын гандангийн засвар	5,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
12	Гонгандан дэдлэн хийдийн халаалт	10,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
13	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар	5,000.0	Хүсэлт, тооцоо судалгаа ирүүлээгүй
	Нийт дүн	225,560.0	

Дээрх байдлаас харахад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгүүлэхээр төлөвлөсөн зарим төсөл, арга хэмжээнд зайлшгүй хэрэгцээ шаардлагатай эсэхийг судлалгүйгээр хуралдааны явцад нэмж баталсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан журмын 3.7 “Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн хүрээний мэдэгдлийг үндэслэн **аймаг, орон нутгийн хэрэгцээ болон саналыг салбарын бодлоготой уялдуулан, өгөгдсөн санхүүгийн эх үүсвэр,**

төсвийн хязгаарт багтаан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төслийг боловсруулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин дээрх байгууллагууд **2018 оны төсөвт хөрөнгө нь батлагдсны дараа** хэрэгцээ, шаардлагатай хөрөнгийн нэр, тоо хэмжээ, хүчин чадал зэрэг техникийн тодорхойлолт хавсаргасан **албан бичгийг аймгийн ХОХБТХ, ИТХуралд ирүүлсэн байна.** /Хавсралт № 1/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зарим төсөл арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан журмын 3.3 “Төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ” гэж заасан байхад орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дээрх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн гэрэлтүүлгийн засварт 10,0 сая төгрөг, Баянбулаг сумын гандангийн засварт 5,0 сая төгрөг, СХЗХэлтсийн Сорьцын лаборторийн засварт 20,0 сая төгрөг, Гон гандан дэдлэн хийдийн халаалтын зуухны засварт 10,0 сая төгрөг, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварт 5,0 сая төгрөг, нийт 50,0 сая төгрөгийн зураг төсөв шаардагдах ТАХ батлагдсан бөгөөд үүнээс СХЗХэлтсийн Сорьцын лаборторийн засвараас бусад төсөл, арга хэмжээнүүд урьдчилсан зураг төсөв, тооцоо судалгаа хийгээгүй байхад төлөвлөж батлуулсан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй төрийн чиг үүрэгт хамааралгүй төрийн бус байгууллагад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийхээр баталсан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй, төрийн чиг үүрэгт хамааралгүй “Баянбулаг сумын гандангийн засвар”-т 5.0 сая, “Гонгандан дэдлэн хийдийн халаалтын засвар”-т 10.0 сая төгрөгөөр засвар хийх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санжүүлэхээр баталсан зөрчил илэрсэн тул цаашид зогсоох зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хууль журмын зохион байгуулсан байна.

худалдан авах ажиллагаатай холбоотой 2 гомдол гарсныг Сангийн яамнаас хянаж, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 36 төсөл арга хэмжээнээс 349,1 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалт, 746.9 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээнд харьцуулалтын арга, 72.7 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулж, 1 төсөл арга хэмжээг тендер зарлах явцад зогсоосон байна.

Харьцуулалтын аргаар зохион байгуулсан төсөл арга хэмжээнд төсөвт байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж худалдан авах 42,9 сая төгрөгийн 7 байгууллагын төсөл арга хэмжээг нэг багц болгон зарлажээ.

Багийн засаг дарга нарын зөөврийн компьютерийг ЗГХЭГ-аас шийдвэрлэх болсон тул тендерийн материал хүлээн авах хугацаанаас өмнө тендерийн үйл ажиллагааг зогсоосон байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 21 төсөл арга хэмжээнээс “Сумдын автомашин /Баянцагаан, Галуут, Бууцагаан, Хүрээмарал, Баянговь/”, “Баян-Өндөр сум автомашин”, “Баянлиг сумын Бохирын автомашин” гэсэн 3 төсөл арга хэмжээг тухайн сумдад нь эрх шилжүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аудитаар аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан 18 төсөл арга хэмжээний тендерийн материалд дүн шинжилгээ хийв.

Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн Засаг даргын захирамжаар нийт 31 хүн үнэлгээний хороонд томилогдсон бөгөөд дээрх гишүүдийн АЗ сертификадыг аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн судалгаа болон tender.gov.mn сайтаас хайлт хийж үзэхэд хугацаа дууссан болон эрхгүй гишүүн байгаагүй.

Шүүхийн шинжилгээний албаны автомашины тендерийг 2018 оны 3-р сард пургон автомашинаар техникийн тодорхойлолтыг ирүүлж зарласан боловч материал ирүүлээгүй шууд гэрээ

байгуулахаар зөвлөмж өгсөн байна. Гэвч техникийн тодорхойлолтыг дахин өөрчлөн “5 суудалтай V 4660 хөдөлгүүрийн багтаамжтай” суудлын тэрэг гэж техникийн тодорхойлолтыг 6-р сард дахин өөрчлөн зарлуулж “Индранил очир” ХХК материал ирүүлснийг шалгаруулсан боловч захиалагч байгууллага тухайн гүйцэтгэгчийн автомашиныг хүлээн авахгүй татгалзсан учир 2018 оны 11-р сард дахин тендер зарлуулж шууд гэрээ байгуулах зөвлөмжийг дахин хүргүүлсэн.

Мөн БОАЖГ нь техникийн тодорхойлолтыг үйлдвэрлэсэн оныг харгалзан үзээгүй, тавьсан шаардлагад нийцсэн машин нь үнэтэй байснаас шалтгаалж 3 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч оролцогч компани материал ирүүлээгүй байна.

Иймд тендер зарлахдаа техникийн тодорхойлолтыг хэрхэн боловсруулах болон бодит үнийн судалгаанд тулгуурлах арга зүйгээр захиалагчдад /ТШЗ/ сургалт зохион байгуулахыг аймгийн ОНӨГ-т зөвлөв.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа www.tender.gov.mn цахим сайтад тендерийн урилгыг бүрэн байршуулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6.1-д заасан “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Үнэлгээний хороо нь тендер шалгаруулахдаа тавигдах шаардлага бүрэн хангаагүй байхад гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тухайлбал:

Төсөвт байгууллагуудад компьютер тоног төхөөрөмж худалдан авах тендерт 4 аж ахуйн нэгж материал ирүүлж “Хос соронз” ХХК-ийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулсан материалд дүн шинжилгээ хийж үзэхэд техникийн шаардлагын 1-д заасан сүүлийн 2 жилийн аудитлагдсан тайлангийн 2016 оны тайлан байхгүй, И-баланс программд илгээсэн талаар харьяа санхүү, төрийн сангийн тодорхойлолт байхгүй, 7-д заасан нийгмийн даатгалын байгууллагад өртэй эсэх талаар мэдээнд дутуу төлөлттэй байсан, 14- т заасан борлуулалтын орлогын дундаж хэмжээ шаардлага хангаагүй, 15- заасан түргэн хөрвөх хөрөнгийн зээл судлагдаагүй, 17-д заасан 2016,2017 онуудад ижил төстэй бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гүйцэтгэлийн захиалагч байгууллагаас ирүүлсэн тодорхойлолт байхгүй зэрэг 6 төрийн шаардлага хангаагүй байна.

Тус тендерт орлоцсон “Нэкст электроникс” ХХК нь хувилагч машиныг техникийн тодорхойлолтын дагуу ирүүлээгүй, нийт үнийн дүнд арифметик алдаа гаргаж 40,4 сая төгрөгийн нийт дүнг 37,9 болгон дүгнэсэн учир тендерт оролцохоос татгалзсан, “Индранил-Очир” ХХК нь техникийн тодорхойлолтын 3-д заасан сүүлийн хоёр жилийн туршлагын мэдээлэл ирүүлэхдээ иргэн Ш.Бүжинлхамтай байгуулсан гэрээ нь багуулсныг хангалтгүй гэж үзсэн, “Дурсамж принт” ХХК нь татварт өртөй атлаа цахим сайтаас авсан

тодорхойлолтыг гараар дарж хуурамч материал бүрдүүлсэн гэсэн шалтгаануудаар тендерээс татгалзсан байна.

Сумдын соёлын төвүүдийн техник хэрэгсэл нийлүүлэх төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг 2018.06.25-нд шалгаруулахдаа 3 оролцогч материал ирүүлсэн боловч, шаардлага хангасан материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн. Гэтэл тендерт оролцогч "Электрон техник" ХХК нь СЯ-нд гомдол гаргасан боловч тендерийн хүчинтэй байх хугацаа дуусч дахин тендер зарлаж 4 аж ахуйн нэгж оролцсон боловч мөн шаардлага хангасан материал ирүүлээгүй гэж үзэн шууд гэрээ байгуулах эрх олгосон. Гэвч "Электрон техник" ХХК нь дахин СЯ-нд гомдол гарган СЯ-наас ирүүлсэн зөвлөмжийн дагуу тендерийг дахин үнэлж "Электрон техник" ХХК тухайн тендерт шалгарчээ.

Улсын бүртгэлийн хэлтэст архивын шүүгээ нийлүүлэх тендерт 2 оролцогч материал ирүүлж "Сутай хайрхан" ХХК-ийг шалгаруулсан боловч Сангийн яаманд "Лүндээ очир" ХХК гомдол гаргаж ирүүлсэн зөвлөмжийн дагуу материалыг дахин үнэлж гомдол гаргасан "Лүндээ очир" ХХК компани шалгарсан байгаагаас үзэхэд үнэлгээний хороо материал үнэлэхдээ бодит бус үнэлснээс дээрх нөхцөл байдал үүсч байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлж ажилласан байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалт: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гэрээний биелэлтийг байгуулсан гэрээ, гэрээний хавсралтад заасан техникийн үзүүлэлт, хүлээж авсан комиссын акттай тулгаж шалгав.

Багийн засаг нарын зөөврийн компьютерийг ЗГХЭГ-аас шийдвэрлэхээр тул тухайн арга хэмжээг хассан. Харин Онцгой байдлын газрын автомашин нь 2 удаа худалдан авах ажиллагаа зохион байгуулсан боловч гүйцэтгэгч ирээгүй, шууд гэрээ байгуулах гүйцэтгэгч олдоогүйгээс тухайн арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.

Гэрээ байгуулсан 32 төсөл, арга хэмжээний 27 төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжиж комиссоор хүлээн авсан бөгөөд "Баянхонгор аймгийн Гон-Ган дэдлэн хийдийн халаалтын засвар" ашиглагч байгууллага хийлгээгүйн улмаас гэрээг цуцалсан, "Залуучуудын хөгжлийг дэмжих зорилтот төсөл хэрэгжүүлэх" төсөл арга хэмжээ нь зарим тоног төхөөрөмж дутуу ирснээс тухайн ажлыг хүлээн аваагүй байна.

Иймд дээрх 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ дуусах хугацаа	хүлээн авсан актын огноо
1	Төсвийн байгууллагуудын техник тоног төхөөрөмж	42,630.0	"Хос соронз" ХХК	2018.05.29	2018.06.12
2	Мэргэжлийн хяналтын газрын Хөрс, ус, хүнсний шинжилгээний багаж	9,890.0	"Нуган трейд" ХХК	2018.05.10	2018.06.20
3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын компьютер, техник хэрэгсэл	25,857.5	"Айетиюнипикэшн" ХХК	Хугацаа тавиагүй	2018.05.12
4	Багийн засаг нарын зөөврийн компьютер	Тухайн ТАХ хэрэгжээгүй			
5	Соёлын төвүүдийн техник хэрэгсэл / Бууцагаан, Баянцагаан, Шинэжинст, Гурванбулаг, Өлзийт/	35,850.0	"Электрон техник" ХХК	2018.12.17	2018.12.29
6	Улсын бүртгэлийн хэлтэст архивын шүүгээ	18,900.0	"Лүндээ-Очир" ХХК	2018.06.08	2018.06.12
7	Хөгжимт драмын театрын хөгжмийн зэмсэг	19,695.0	"Хонгор радус" ХХК	2018.07.17	2018.10.09
8	Залуучуудын хөгжлийг дэмжих зорилтот төсөл хэрэгжүүлэх	29,950.0	"Хос соронз" ХХК	2018.10.16	Хүлээж аваагүй
9	Онцгой байдлын газрын автомашин	Тухайн ТАХ хэрэгжээгүй			
10	Шүүхийн шинжилгээний албаны автомашин	30,800.0	Х. Оюунсүрэн	2018.12.22	2018.12.19
11	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын автомашин	31,000.0	"Ганди Данди" ХХК	2018.06.29	2017.05.02
12	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж	40,000.0	"Мед импекс Интернэшнл" ХХК	2019.09.03	2018.09.10
13	Хот тохижилт, үйлчилгээний газрын автомашин	9,500.0	"Айети юнипикэшн" ХХК	Хугацаа тавиагүй	2018.03.30
14	Өрхийн эмнэлэгийн автомашин	23,600.0	"Индранил-Очир" ХХК	2018.05.27	2018.06.10
15	Хүрээмарал /Суудлын автомашин/	49,800.0	Б.Ууганцэцэг	2018.11.12	2018.11.12
16	Бууцагаан /Суудлын автомашин/	49,800.0	"Буянт богдын хишиг" ХЗХ	2018.05.05	2018.05.07
17	Баянцагаан /Суудлын автомашин/	59,800.0	Р.Баасандагва	2018.11.11	2018.11.12
18	Галуут /Суудлын автомашин/	49,800.0	В.Жавзаннамжил	2018.06.16	2018.06.26
19	Баянговь /Суудлын автомашин/	55,000.0	"Индранил-Очир" ХХК	2018.12.01	2018.10.12
20	Багийн Засаг дарга нарын мотоцикл /77/	127,820.0	"Бүдума" ХХК	2018.07.04	2018.07.23
21	Багийн эмч нарын мотоцикл /36/	59,760.0	"Бүдума" ХХК	2018.06.31	2018.07.23
22	Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн гэрэлтүүлгийн засвар	10,000.0	"Си Ай Ти" ХХК	2017.12.28	2017.12.25
23	Баянбулаг сумын гандангийн засвар	5,000.0	С.Хүрэлбаатар	2018.05.15	Баримт материал ирүүлээгүй
24	Стандарт хэмжил зүйн төвийн Сорьцын лабораторийн засвар	34,725.2	"Баян товгор" ХХК	2018.07.02	2018.07.05
25	Баянхонгор аймгийн Гон-Ган дэдлэн хийдийн халаалтын засвар	10,000.0	"Ингүмэл дөл" ХХК	2018.09.30	Тухайн ажил хэрэгжээгүй
26	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар автомашин	45,110.0	"Тайжийн-Овоо" ХХК	2018.08.10	2018.08.13
27	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар	5000.0	Баримт материал ирүүлээгүй		
28	БОАЖГ-ын автомашин	80,000.0	"Ар цахир транс" ХХК	2018.12.26	2018.12.25
29	Улаанзагалмай автомашин	30,000.0	"Хос соронз" ХХК	2018.11.15	2018.11.14

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

30	Баян-Өндөр сум автомашин	49,500.0	"Илч шим" ХХК	Хугацаа тавиагүй	2018.11.14
31	Баянлиг сумын Бохирын автомашин	29,800.0	"Баялаг-Өлзий" ХХК	2018.11.14	2018.11.14
32	Бөмбөгөр сумын ЗДТГ-ын халаалтын засварт	9000.0	Баримт материал ирүүлээгүй		
33	Хувийн усан сангуудыг төрийн өмчид худалдан авах	13,656.0	8 усан санч	Тухай бүр нь гэрээ хийсэн	Тухай бүр нь хүлээж авсан
34	Онцгой байдлын газрын Орон сууц	51,147.0	"Би Эйч Энд ди"ХХК	2019.01.25	2019.01.25
	Дүн	1,128,390.7			

ХБХОТХ-ийн хөрөнгө оруулалтын ажлын баримт материалаас “Баянбулаг сумын гандангийн засвар”, “Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар”, “Бөмбөгөр сумын ЗДТГ-ын халаалтын засвар”-ын нийт 19.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн ажлын тайлан баримт материал, ирүүлээгүй байгаа тул дээрх ажлын тайлан материалыг авч хэрэгжилтийг ирүүлэх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХБХОТХ-т өгөв.

Хүлээн авсан 27 төсөл арга хэмжээний хувьд хүлээн авсан акт, холбогдох гэрчилгээ, техникийн баримт бичигтэй тулган үзэхэд гэрээнд заасан үзүүлэлттэй тохирч байлаа.

Гэрээний хугцааг тооцож үзэхэд гэрээнд Мэргэжлийн хяналтын газрын Хөрс, ус, хүнсний шинжилгээний багаж, Хөгжимт драмын театрын хөгжмийн зэмсэг, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар автомашин нийлүүлэх гэрээнд алданги тооцох заалтыг оруулаагүй байна. Харин алданги тооцох харицлага тооцсон дараах 5 төсөл арга хэмжээг тооцож үзэхэд 754.7 мянган төгрөгийн алдаги гарахаар байхад тооцоож ажиллаагүй байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний үнэ	Дуусах	Актын огноо	Хэтрүүлсэн хоног	Хариуцлага	Тооцсон дүн
A	1	2	3	4			0.0
1	Төсвийн байгууллагуудын техник тоног төхөөрөмж	42,630.0	2018.05.29	2018.06.12	15	0.005	213.2
2	Соёлын төвүүдийн техник хэрэгсэл / Бууцагаан, Баянцагаан, Шинэжинст, Гурванбулаг, Өлзийт/	35,850.0	2018.12.17	2018.12.29	12	0.005	179.3
3	Улсын бүртгэлийн хэлтэст архивын шүүгээ	18,900.0	2018.06.08	2018.06.12	4	0.005	94.5
4	Залуучуудын хөгжлийг дэмжих зорилтот төсөл хэрэгжүүлэх	29,950.0	2018.10.16		211	0.005	149.8
5	Өрхийн эмнэлэгийн автомашин	23,600.0	2018.05.27	2018.06.10	14	0.005	118.0
		300,350.2	-	-			754.7

Иймд дээрх 754.7 мянган төгрөгийн алдагийг нөхөн тооцож, гүйцэтгэгч байгууллагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Сумдын ЗДТГ-т олгосон орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын зардал:

Сумдын ЗДТГазрын 2018 оны үйл ажиллагааны зардалд тооцож олгосон зорилтот хөрөнгө оруулалтын зардал 902885.4 мянган төгрөгөөр батлагдаж санхүүжилтийг бүрэн олгосон байна. Олгосон санхүүжилтээс зарцуулагдаагүй 90405,3 мянган төгрөгийг сумдын ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлжээ.

Сумын ЗДТГазар олгосон зорилтот хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харууллаа.

д.д	сумдын ЗДТГ	Зарцуулах эрх	олгосон санхүүжилт	Зарцуулалт	буцааж төвлөрүүлсэн
1	Өлзийт	26,729,900.00	26,729,900.00	26,729,900.00	-
2	Жинст	27,826,800.00	27,826,800.00	27,525,000.00	301,800.00
3	Богд	34,219,500.00	34,219,500.00	34,219,000.00	500.00
4	Баянлиг	69,417,200.00	69,417,200.00	69,127,200.00	290,000.00
5	Баянговь	30,884,000.00	30,884,000.00	20,185,000.00	10,699,000.00
6	Шинэжинст	67,254,300.00	67,254,300.00	66,654,300.00	600,000.00
7	Баян-Өндөр	72,936,800.00	72,936,800.00	42,986,270.00	29,950,530.00
8	Баянцагаан	54,040,500.00	54,040,500.00	53,162,706.00	877,794.00
9	Баацагаан	45,635,100.00	45,635,100.00	19,463,900.00	26,171,200.00
10	Бөмбөгөр	30,664,700.00	30,664,700.00	30,660,000.00	4,700.00
11	Бууцагаан	49,940,600.00	49,940,600.00	49,940,600.00	-
12	Хүрээмарал	30,300,000.00	30,300,000.00	30,218,600.00	81,400.00
13	Баянбулаг	29,147,400.00	29,147,400.00	9,800,000.00	19,347,400.00
14	Гурванбулаг	61,855,400.00	61,855,400.00	61,855,400.00	-
15	Заг	26,595,000.00	26,595,000.00	26,595,000.00	-
16	Жаргалант	36,402,500.00	36,402,500.00	34,901,700.00	1,500,800.00
17	Галуут	30,600,000.00	30,600,000.00	30,218,600.00	381,400.00
18	Баян-Овоо	-	-	-	-
19	Эрдэнэцогт	30,672,100.00	30,672,100.00	30,672,000.00	100.00
20	Баянхонгор	147,763,600.00	147,763,600.00	147,564,900.00	198,700.00
	Дүн	902,885,400.00	902,885,400.00	812,480,076.00	90,405,324.00

Сумдын ЗДТГазарт олгосон дээрхи санхүүжилтээс хөрөнгө оруулалтын бус урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан, зайлшгүй хэрэгцээ шаардлага хангаагүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн зөрчил зарим суманд идэрлээ. Тухайлбал: Шинэжинст сумын ЗДТГазар хилийн цэргийн Цагаан богд заставын Соёлын төвийн барилгын дээврийн засварт 10,0 сая төгрөг олгож, заставын даргатай гэрээ байгуулсан, Баянговь сумын ЗДТГазар аж ахуйн бараа материал худалдан авахад 685,0 мянган төг, Богд сумын ЗДТГазар сэлбэг худалдан авахад 737,0 мянган төгрөг байна.

Жинст сум нийтийн биеийн тамирын тэмцээний зардалд 4,0 сая төгрөг зориулалт бусаар зарцуулсан тул төлбөрийн акт тогтоов.

Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын зардлаас 90905,3 мянган төгрөгийг зарцуулалгүй буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд:

Баацагаан сум багийн шинээр барихад 26,0 сая батлагдсан бөгөөд 2018 оны 8-р сард тендер зарлаж, 2 байгууллага материал ирүүлсэнч шаардлага хангаагүй тул сонгон шалгаруулаагүй, улмаар 11, 12-р сар хүртэл материал ирээгүй тул мөнгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Баян-Өндөр суманд 2017 онд ОНХСангийн хөрөнгөөр баригдсан Спорт цогцолбрын барилгын үлдэгдэл санхүүжилт 17354,1 мянган төгрөгийг 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас олгохоор батлуулсан бөгөөд уг ажлыг улсын комисс хүлээн аваагүйтэй холбоотойгоор олгоогүй, бусад зардлын хэмнэлтээр 12596,1 мянган төгрөг үлдсэн тул 29,9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Баянговь сум 2018 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд автомашины үнэ 10,0 сая төгрөг батлагдсан боловч, 5,2 сая төгрөг шилжүүлсэн, бусад батлагдсан төсөл арга хэмжээнээс 5,0 орчим сая төгрөг хэмнэгдэж, 10,7 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Жимс, жимсгэнэ хөтөлбөрийн “эрүүл жимсийг өөрийн хашаандаа” төсөл:

Засгийн газрын 2016-2020 онд хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.40 дэх заалт болон Баянхонгор аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн 124 дүгээр зүйлд “Жимс, жимсгэнэ, хүнсний ногоо үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх” ажилд 50,0 сая төгрөг батлагдсаны дагуу аймгийн ИТХ-ын 2017.12.04-ний 8 дугаар хуралдааны 8/3 тоот тогтоолоор жимс, жимсгэний тариаланг дэмжих арга хэмжээнд 50,0 сая төгрөг баталсан байна.

Энэ хүрээнд аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорациар дамжуулан “Өвдгийн шанд” “Гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага”-ын захирал Б.Отгонбилэгтэй АГГ-2018/01/01 тоот гэрээ байгуулан зорилтот бүлгийн 30 өрхийн амьжиргааг дэмжих “Эрүүл жимсийг хашаандаа” төслийг хэрэгжүүлсэн байна.

Гэрээний дагуу аймгийн мод үржүүлгийн талбайн ард 30 өрхийн хашааг барьж, өрх бүрд жимсний мод /үхрийн нүд мод 30ш, чацарганы мод 18ш, интоорын мод 17ш, бөөрөлзгөний мод 13ш, Хөх далан халь мод 10 ш/ 88 ширхэгийг технологийн дагуу суулгаж, гүний худаг гаргаж, усалгааны систем олгож, түүний ургуулалт, арчлалтыг хангаж, хамтран ажиллах 3 жилийн гэрээ байгуулсан байна.

Аудитаар уг төслийн хэрэгжилтийг шалгахад гэрээний дагуу хийгдэх ажлууд бүрэн хийгдсэн, жимсний модны ургалт боломжийн хэмжээнд, хамарсан өрх, иргэдийн сэтгэл ханамж сайн байна.



Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх зээл: Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн 101 дэх заалтад “Баянхонгор сумын хэмжээнд хоршоо, бүлэг бий болгож ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр “Айл хотлоороо үйлдвэрлэгч болж нийт 18 хоршоо бүлэг байгуулагдан ажлын байр нэмэгдүүлнэ”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 81-т “аймгийн хэмжээнд байнгын шинэ ажлын байр бий болгосон үйлдвэрлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төслөөр дэмжинэ” гэж заасны дагуу Үйлдвэржилт хөгжлийн корпорациар дамжуулан жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх 400,0 сая төгрөгийн зээл олгохоор ИТХ-ын хуралдааны тогтоолоор баталсан байна.

Дээрх тогтоолын хэрэгжилтийг хангахын тул аймгийн ИТХТ-ийн 2018.02.21-ний 19-р тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-д өөрчлөлт оруулж баталж, хэрэгжүүлж байна.

ЖДҮ-ийн зээлийн талаар Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорациас Баянхонгор телевизид 14 хоногийн зар өгч, телевизээс 7 хоногийн үнэгүй зарлах урамшуулал олгож, нийт 21 хоногийн турш зар сурталчгаа явуулсан байна. Мөн Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци өөрийн Facebook хаягаар зарлал тавьж олон нийтэд түгээсэн байна.

ЖДҮ-г хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулах комиссын хуралдаан 2018.04.16-ны өдөр хуралдаж ЖДҮ-ийн чиглэлээр 87 төсөл ирүүлснээс аялал жуулчлын чиглэлийн 5 төсөл, бусад чиглэлийн 11 төслийг шалгаруулсан байна.

Аялал жуулчлалын бааз байгуулах төслийг комиссын гишүүд 1-5 оноо өгөх зарчмаар хамгийн өндөр оноо авсан төслүүдийг шалгаруулжээ. Харин бусад төслүүдийг комисс ярилцаад санал хураагаад шалгаруулсан байна.

2018 онд Баянхонгор аймгийн үйлдвэржилт хөгжлийн корпорацид ЖДҮ-ийн зээлд зориулж 400,0 сая төгрөгийн санхүүжилт олгож, дараах төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Д.д	Огноо	Хэнд олгосон	Зориулалт	хэмжээ
1	2018.05.29	Ж.Өлзийбат	Модон эдлэлийн тоног төхөөрөмж авах	25,000,000
2	2018.06.05	Х.Энхбаяр	Модон эдлэлийн тоног төхөөрөмж авах	17,000,000
3	2018.05.28	О.Мягмар	Ажлын цагаан бээлий үйлдвэрлэх тоног төхөөрөмж	20,000,000
4	2018.05.28	Д.Мөнхзул	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	3,000,000
5	2018.06.12	Г.Цэцэгбал	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	5,000,000
6	2018.05.25	Т.Цэцэгмаа	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	7,000,000
7	2018.05.28	Н.Гантөмөр	Гутлын цех өргөжүүлэх тоног төхөөрөмж авах	10,000,000
8	2018.06.12	С.Батбаатар	Бейкери өргөжүүлж, сав баглаа боодол авах	10,000,000
9	2018.05.25	Б.Баяндалай	Уламжлалт болон сэргээн засан физик эмчилгээ байгуулах	5,000,000
10	2018.05.25	Г.Доржнамжаа	Витамины тэжээл-малын тэжээл үйлдвэрлэх	30,000,000
11	2018.06.05	М.Мянганбуу	Аялал жуулчлалын түр оператор байгуулах, тоног төхөөрөмж авах	13,000,000
12	2018.05.25	Х.Баянмөнх	Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх	40,000,000
13	2018.06.26	М.Түмэнбаяр	Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх	60,000,000
14	2018.05.28	В.Наранбаяр	Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх	60,000,000
15	2018.05.24	Ц.Хишигхүү	"Улиатайн ам" аялал жуулчлалын бааз байгуулах	25,000,000
16	2018.10.18	Б.Наранцацрал	Албан хэрэгцээний бичгийн цаас үйлдвэрлэх	15,000,000
		Нийт дүн		345,000,000

2018 онд олгосон 400,0 сая төгрөгийн санхүүжилтээс 345,0 сая төгрөгийн зээл олгож, 55,0 сая төгрөг олгогдоогүй харилцах дансанд үлдсэн байна.

Аудитаар дээрхи зээлийн хэрэгжилтийг шалгахад 105.0 сая төгрөгийн 3 төслийн үйл ажиллагаа эхлээгүй байгаа нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 19-р тогтоолоор баталагдсан “Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журам”-ын 7.2-т “Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүжилтээ авснаас хойш 60 хоногийн дотор үйл ажиллагаагаа эхлүүлсэн байх ёстой” гэсэн заалтыг зөрчсөн байна.

➤ Витаминт тэжээл үйлдвэрлэл үйлдвэрлэх төсөл нь тоног төхөөрөмжөө худалдан авч үйлдвэрлэл эхлүүлсэн боловч түрээсэлж байсан Шаргалжуут рашаан сувилалын байрыг цаашид түрээслэх боломжгүй болсны улмаас Баянхонгор аймгийн төвд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхээр төлөвлөсөн хэдий ч аудитын хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байна.

➤ Албан хэрэгцээний бичгийн цаас үйлдвэрлэх төслийн зээлдэгч нь тоног төхөөрөмжөө худалдан авсан боловч, угсарч байрлуулаагүй, үйл ажиллагаагаа эхлээгүй байна.

➤ Бага шаргалжуутад аялал жуулчлалын бааз байгуулах төсөл нь төсөлд тусгагдсан ажилчдын байр 70-80 хувь баригдсан, үерийн хамгаалалтын далан хийсэн, хөрсний шинжилгээ хийлгэж байгаа бөгөөд цахилгааны шугам холбох, бохирын шугам холбох ажлууд хийгдээгүй үйл ажиллагаа эхлээгүй байна.

Иймд төсөлд заасан үйл ажиллагаагаа эхлээгүй 105.0 сая төгрөгийн 3 төслийн зээлдэгч нарт ажлыг эхлүүлэх хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Бусад төсөл арга хэмжээ хэвийн ажиллаж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.

д.д	Зээлдэгчийн нэр	Зориулалт	Олгосон зээлийн хэмжээ /сая.төг/	Хэрэгжилт
1	Ж.Өлзийбат	Модон эдлэлийн тоног төхөөрөмж авах	25.0	токарын машин, градустай хөрөө, үртэс сорогч, тайга хөрөө худалдан авах төслөөр зээлд хамрагдаж, худалдан авч үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
2	Х.Энхбаяр	Модон эдлэлийн тоног төхөөрөмж авах	17.0	суурин призер, сундаг тавцантай хөрөө рам, компрессор худалдан авах зорилгоор зээлд хамрагдсан бөгөөд тоног төхөөрөмжөө худалдан авч үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
3	О.Мягмар	Ажлын цагаан бээлий үйлдвэрлэх тоног төхөөрөмж	20.0	шинээр тоног төхөөрөмж болон түүхий эдээ татан авч үйл “Ажилсаг” төвд байршуулан, үйл ажиллагаа хэвийн жигд явж байна.
4	Д.Мөнхзул	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	3.0	оёдлын машин авсан, хэвийн ажиллаж байгаа
5	Г.Цэцэгбал	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	5.0	оёдлын машин авсан, хэвийн ажиллаж байгаа
6	Т.Цэцэгмаа	Оёдлын цехээ өргөжүүлэх, тоног төхөөрөмж авах	7.0	оёдлын машин авсан, хэвийн ажиллаж байгаа

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

7	Н.Гантөмөр	Гутлын цех өргөжүүлэх тоног төхөөрөмж авах	10.0	тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаа нь “Ажилсаг” төвд хэвийн жигд явагдаж байна.
8	С.Батбаатар	Бейкери өргөжүүлж, сав баглаа боодол авах	10.0	сав баглаа, боодлыг сайжруулах арга хэмжээнд 10,0 сая төгрөгийн зээл авч сав баглаа боодлоо шинэчлэн, үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
9	Б.Баяндалай	Уламжлалт болон сэргээн засан физик эмчилгээ байгуулах	5.0	уламжлалт болон сэргээн засах физик эмчилгээ хийх эмнэлэг байгуулах зорилгоор төсөлд хамрагдаж, хаш чулуун массажны ор, бариа заслын ор, цахилгаан зүүний аппарат, эмийн шүүгээ, зэм бумба зэрэг тоног төхөөрөмжүүдийг худалдан авч, үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
10	М.Мянганбуу	Аялал жуулчлалын түр оператор байгуулах, тоног төхөөрөмж авах	13.0	13,0 сая төгрөгийн зээл авч, зөөврийн компьютер 2ш-5,0 сая төгрөг, принтер 1ш-1,0 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 7,0 сая төгрөгөөр худалдан авсан, аялал жуулчлалын Баяннуур ХХК байгуулсан бөгөөд одоогоор үйл ажиллагаа нь жигдрээгүй
11	Х.Баянмөнх	Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх	40.0	100 хүн хүлээн авах гал тогооны барилга барих, 20 тн-ын контейнерт 2ш душ, 2ш угаалтуур, 2ш бие засах өрөө бүхий байгууламж барихаар зээлд хамрагдсан бөгөөд зээлд хамрагдснаар стандартад нийцсэн нойл, душ болон амралтын байр, рестораныг барьж ашиглалтад оруулаад үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
12	В.Наранбаяр	Аялал жуулчлалын бааз хөгжүүлэх	60.0	7*7, 10*40 хэмжээтэй амрагчын 2 байрыг барьж нэгийг нь ашиглалтад оруулсан, нэг барилгын ажил 80-90 хувь гүйцэтгэлтэй байна. Үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
13	Ц.Хишигхүү	"Улиатайн ам" аялал жуулчлалын бааз байгуулах	25.0	нэг байшинд өргөтгөл хийж, нэг байшин шинээр барьж, 3 гэр шинээр худалдан авч гадаад дотоодын жуулчдыг хүлээн авч үйл ажиллагаа нь хэвийн жигд явагдаж байна.
Нийт дүн			240.0	

Торгон сүрэг:

Аймгийн ИТХ-ын 2017 оны 8-р хуралдааны тогтоолоор ангилагдаагүй зардлаас “Торгон сүрэг” аймгийн дэд хөтөлбөрт 50,0 сая төгрөг батлагдаж, аймгийн Засаг даргын 2018.05.28-ны А/400 дугаар захирамжаар “Торгон сүрэг бүрдүүлэх” эрхийг Шинэжинст, Бөмбөгөр, Хүрээмарал сумдад шилжүүлжээ. Захирамжийн хавсралтад сум бүр 206 хээлтүүлэгчийг 12360,0 мянган төгрөгөөр бэлтгэх, өвс тэжээлийн үнэ 3,0 сая төг, өвөлжөө хаваржааны зардалд 1305,0 мянга, нийт 16665,0 мянган төгрөг хуваарилжээ. Энэ захирамжийн дагуу 2018.06.08-нд Шинэжинст, Бөмбөгөр, Хүрээмарал сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансруу тус бүр 16665,0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын үнэлгээний хорооны 2018.09.05-ны Б/151 албан тоот бичгээр Шинэжинст суманд бог малын хээлтүүлэгчийн сан бүрдүүлэх ажилд нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2018.08.28-аас 2018.09.04-ны хооронд зарласан

боловч нэгч аж ахуйн нэгж материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын 2018.10.15-ны 250 тоот албан бичгээр “Залаа жинст торгон сүрэг” хоршоонд бог малын хээлтүүлэгч бэлтгэх ажилд гэрээ байгуулах саналыг хүргүүлж, гүйцэтгүүлсэн байна.

Шинэжинст сумын ЗДТГ болон “Залаа жинст торгон сүрэг” хоршооны хооронд 2018.10.15-ны өдөр БХ-ШЖ-2018/ШХА-10 тоот 12360,0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 2018.12.05-ны өдөр 206 толгой цагаан зүсмийн ухна ишгийг хүлээн авч, ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд орлого авсан байна.

Малчин Г.Баатар, Ц.Эрдэнэчимэг нартай 2019.01.31-нд хээлтүүлэгч ухна ишгийг 2019.01.01-2020.01.01-ний хугацаанд маллуулах гэрээ байгуулан ажиллаж байна.

Хүрээмарал сумын ЗДТГ болон “Ар халзан бугат” хмал үржлийн аж ахуйн нэгжийн хооронд 2018.08.05-ны өдөр 12360,0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 206 толгой “Баяд” үүлдэрээр сайжруулсан хурган хуцыг хүлээн авч, ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд орлого авсан байна.

Норовлин 3-р багийн малчин Т.Баяраа, Д.Саранхөхөө нартай 2018.09.27-нд хээлтүүлэгч хурган хуцыг маллуулах гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээнд гэрээний үргэлжлэх хугацаа тодорхойгүй, “Торгон сүрэг”-ийн ашиглалт, үр дүнгийн талаар тодорхой тусгаагүй байна.

Бөмбөгөр сумаас “Торгон сүрэг”-ийн бэлтгэн нийлүүлэлттэй холбоотой материал ирүүлээгүй тул холбогдох хүмүүст хариуцлага тооцох саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэв

Аудитын газраас 2017 оны “Торгон сүрэг” бүрдүүлэлтэд хийсэн аудитаар бэлтгэн нийлүүлэгч нь гэрээнд заасан хээлтүүлэгчийг дутуу, чанаргүй нийлүүлсэн, нийлүүлсэн хээлтүүлэгч нь тухайн онд олноор үхэж хорогдсон зэрэг хариуцлагагүй байдал илэрч байсан тул “Торгон сүрэг”-ийн цаашдийн үр дүн, үр нөлөөг сайжруулах, ашиглалтад тавих хяналтын талаар тусгай журам гаргаж, мөрдүүлэх, мөн сумын Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс, аймгийн ХХААГазрын хооронд хамтарсан “Торгон сүрэг”-ийн ашиглалт, хамгаалалт, үр дүн, хариуцлагын талаар тодорхой заалт бүхий гэрээ байгуулж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

Гүйцэтгэгч байгууллагад олгох санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь тулгуурлан олгосон байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аймгийн Төрийн сангийн 100030051300 дансаар дамжуулан гүйцэтгэсэн байна. Тухайн дансаар нийт 1063,8 сая төгрөгийн санхүүжилт хуваарилаж, 35 төсөл арга хэмжээнд 975,9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 87,9 сая төгрөгийн үлдэгдлийг оны эцэст орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэгч байгууллагад олгосон санхүүжилтээс Залуучуудын хөгжлийг дэмжих зорилтот төсөл хэрэгжүүлэх 5,2 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон нь нийлүүлж буй тоног төхөөрөмж дутуу ирсэн, Стандарт хэмжил зүйн төвийн Сорьцын лабораторийн засварт 10.5 сая төгрөг дутуу олгосон нь гүйцэтгэгч компани гүйцэтгэлийн материалаа дутуу бүрдүүлсэн, Баянхонгор аймгийн Гон-Ган дэдлэн хийдийн халаалтын засвар 5 сая төгрөг олгосон нь тухай ажлыг хийдийн захиргаанаас хийлгээгүй, Баянлиг сумын бохирын автомашин нь 200.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь сумд эрх шилжүүлэхдээ дутуу шилжүүлсэн зэрэг шалтгаантай байна.

Харин Багийн Засаг дарга нарын 77 мотоцикл, Багийн эмч нарын 36 мотоциклийн санхүүжилтийг 3420.0 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн байгаа нь тухайн зардлын тендерийн хэмнэлтийг аймгийн ИТХ-ын 2018.07.08-ний өдрийн 12/02 тогтоолоор хасч зохицуулалт хийгдсэн байхад хэмнэлтийг гүйцэтгэгч “Бүдума” ХХК-тай гэрээ байгуулан 2 мотоцикл нэмж авч батлагдаагүй төсөл арга хэмжээ санхүүжүүлсэн тул цаашид батлагдаагүй төсөл арга хэмжээ санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв. Дээрх хөрөнгө оруулалтын ажлуудаас бусад төсөл арга хэмжээг гэрээнд заасны дагуу бүрэн санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл, арга хэмжээний гэрээний гүйцэтгэлд тавих хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх засварын 4 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьсан тухай холбогдох баримтыг ХОХБТХэлтсээс гаргаж ирүүлээгүй, тухайн ажлуудад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Мөн зарим төсөл арга хэмжээний гэрээнд хариуцлага тооцох заалт оруулаагүй, гэрээний хугацаанд хяналт тавьж ажиллаагүйгээс хугацаа хэтрүүлсэн зөрчил илрэв.

Харин ЖДҮ-ийн зээлийн хяналтыг аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпораци тогтмол, үр нөлөөтэй гүйцэтгэж, зээлийн эргэн төлөлт зохих хэмжээнд явагдаж байна.

2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй, үр ашигтай хэрэгжсэн эсэх

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь бодит үр дүнд хүрсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний бодит үр дүнг тооцож ажилласан байна.

Баянхонгор аймагт Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн төсөл арга хэмжээнүүдийн бодит үр дүнг тооцсон байна.

Тухайлбал:

- Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ ирүүлсэн судалгаагаар Багийн Засаг дарга нарыг унаажуулснаар төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх, цаг үеийн мэдээллийг цаг тухай бүрт нь иргэдэд хүргэдэг болсон.
- Стандарт хэмжил зүйн төвийн сорьцийн лаборатори ашиглалтад орох нөхцөл бололцоог бүрдүүлснээр далд хэлбэрээр арилждаг байсан алтыг улсын санд тушаалгах болсон.
- Соёлын байгууллагуудад хөгжим, техник хэрэгсэл авч өгснөөр соёлын үйл ажиллагааны хүртээмж сайжирсан.
- Хувийн усан сангуудыг орон нутгийн өмчлөлд худалдан авч дэвшилтэд үйлчилгээ нэвтрүүлснээр иргэдэд хүргэх усан хангамжийн ариун цэврийн шаардлага хангах, үйлчилгээг иргэдэд хүндрэлгүйгээр хүргэж байгаа.
- Төсөвт байгууллагуудын авто машин, тоног төхөөрөмжийг шинэчилснээр төрийн хэвийн ажиллах нөхцөл бололцоо хангасан зэрэг бодит үр дүн гарсан байна.

Хяналт сул байгаагаас хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь ашиглагч байгууллагын эзэмших эрхийг шилжүүлж аваагүй, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хамааралгүй байгууллагад хөрөнгө бэлтгэх зөрчил байсаар байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийн эзэмшигчийг тогтоох тухай аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолоор 8 төсөл арга хэмжээний 182,7 сая төгрөгийн хөрөнгийг, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 01-р сарын 31-ний өдрийн №17 тоот тогтоолоор 18 төсөл арга хэмжээний 849,6 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшүүлсэн байна.

Харин аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад хөрөнгө бэлтгэж өгч байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.6.6-д заасан “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.” гэсэн заалттай зөрчилдөж байгаа

тул цаашид босоо бүтэцтэй байгууллагад хөрөнгө бэлтгэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд орон нутгийн өмчид бүртгүүлэн, хөрөнгө ашиглалтын гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжиж хэрэгжсэн ТАХ-нүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгасан эсэхийг ашиглагч байгууллагуудын санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн орлогын журналыг авч тулган шалгахад хөрөнгө бүртгээгүй төсөл арга хэмжээ байхгүй байна.

Харин Баянлиг сумын Бохирын автомашин, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын авто машин Багийн Засаг дарга нарт хуваарилсан 79 ширхэг мотоциклийн эзэмшлийг ашиглагч байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нийт 158.0 сая төгрөгийн зөрчил илэрч 4.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 154.0 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлж, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 7 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байн а. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг урьчилан тооцоогүй байхад хуралдааны явцад хэлэлцэж батласан байна.
2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй төрийн чиг үүрэгт хамааралгүй төрийн бус байгууллагад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар засвар хийхээр баталсан байна.
3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой 2 гомдол гарсныг Сангийн яамнаас хянаж, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзсэн байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид олгох санхүүжилтийг бодит гүйцэтгэлд нь тулгуурлан олгосон байна.
5. Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн төсөл арга хэмжээний бодит үр дүнг тооцож ажилласан байна.
6. Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь ашиглагч байгууллагын эзэмших эрхийг шилжүүлж аваагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Г.Батжаргал танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд нийцүүлэн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулж батлуулах.
2. Аймгийн ИТХ-аар батлагдаагүй төсөл арга хэмжээ санхүүжүүлэхгүй байх.
3. Төсвийн тухай хуулийг 6.6.6 заалтыг зөрчин ТЕЗ-ийн харьяанд хамаарагддаггүй байгууллагад хөрөнгө бэлтгэдэг байдлыг таслан зогсоох.
4. ТЕЗ-ийн харьяанд хамаарагддаггүй байгууллагад 2018 онд бэлтгэж өгсөн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгүүлэн, хөрөнгө ашиглалтын гэрээ байгуулж ажиллах.
5. “Торгон сүрэг”-ийн үр дүн, үр нөлөөг сайжруулах, ашиглалтад тавих хяналтын талаар журам гаргаж, аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, аймгийн ХХААГазрын хооронд хамтарсан гэрээ байгуулж ажиллах.

Аймгийн Орон нутгийн Өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх танаа:

1. Орон нутгийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн эзэмших эрхэд хяналт тавьж ажиллах.
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг үндэслэлтэй боловсруулах асуудлаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний байгууллагуудад сургалт сурталчилгааг зохион байгуулах.